байлцаж, Цай Тунго, Лю Силянь нар хэлмэрчилж, тэмдэглэлийг Жан Зай хөтөлжээ.

Мао Зэдун төлөөлөгчдийг талархан угтаж байгаагаа илэрхийлэхэд Кубын хувьсгалчид тэмцэлдээ Мао даргыг ямагт хүндлэл бишрэлийн бэлгэдэл гэж үздэг хэмээн Гевара командлагч хариу хэлэв. Харилцан яриа цааш ийн өрнөжээ.

Мао Зэдун: Та чинь аргентин хүн бил үү?

Эрнесто Че Гевара: Би бол Аргентинд төрж өссөн.

Мао: Бусад нь хаана төрсөн хэн хэнсэн билээ?

Гевара: Энд 4 улсын төлөөлөл байна. Энд яваа Эквадорын хувьсгалт социалист намын

Ерөнхий нарийн бичгийн дарга Рамиро Фернандо Мальдонадо бол эквадор хүн, эдийн засагч Албан Латасте бол чили хүн, бусад нь кубачууд. Бидний зарим нь Кубад төрж өсөөгүй ч Кубад төрсөнгүй гэж кубын ард түмэн тээршаадаггүй, харин ч бид Кубын хувьсгалыг хамтран хамгаалж байна. Фидель Кастро нь бүх латинамерикчуудын хүсэл тэмүүллийг илэрхийлж байна.

Мао: Тэгэхлээр Та нар чинь интернационалчид юм шив дээ?

Гевара: Латин Америкийн интернационалчид.

Мао: Азичууд, африкчууд, нийт социалист лагерь Хятадыг дэмжиж байна. Азийн хэд хэдэн улсаар айлчлав уу?

Гевара: Энэтхэг, Сиам, Таиланд, Индонез, Бирм, Япон, Пакистанаар орлоо.

Мао: Хятадыг эс тооцвол Та нар чинь Азийн үндсэн гол орнуудаар оржээ. Одоо Хятадад тавтай морилогтун!

Гевара: Би өнгөрсөн онд Кубыг орхин явах үед манай дотоод байдал тогтворжих явцдаа байсан. Яагаад бид өнөөгийнх шиг гадаад ертөнцтэй зугуухан харилцаж байв гэхлээр одоо дотоод байдал төвхнөсөн, бид цэх, итгэлтэй байж болно.

Мао: Өнгөрсөн онтой харьцуулахад олон улсын өнөөгийн байдал дээрдсэн.

Гевара: Бүх улс түмэн нэг юм. Гэвч империалистууд биднийг салгах гэж өдөр бүхэн чармайж адгаж байна.

Мао: Ажилчин тариачнаас гадна Та бүхэнтэй өөр хэн нэгдсэн бэ?

Гевара: Манай Засгийн газар ажилчин тариачныг төлөөлж байна. Манай оронд бидэнтэй найрсгаар харилцаж хамтран ажиллаж байгаа жижиг хөрөнгөтнүүд байсаар байна.

Мао: Үндэсний хөрөнгөтнүүд үү? Байсаар л байгаа юм уу?

Гевара: Үндэсний хөрөнгөтнүүд маань үндсэндээ импортоор орж ирэгсэд юм. Тэдний эрх ашиг империализмтай хутгалдаад бидний эсрэг байсан. Тийм учраас бид тэднийг эдийн засгийн талаас нь ч, улс төрийн талаас нь ч устгасан.

Мао: Тэд бол бууж өгсөн долдой хөрөнгөтнүүд. Тэднийг үндэсний хөрөнгөтөн гэж үзэхгүй.

Гевара: Манай зарим хүмүүс империализмаас бүрэн хараат байлаа. Империализм тэдэнд капитал, технологи, патент, зах зээл өгчээ. Тэд хэдийгээр эх орондоо аж төрж байсан ч тэдний эрх ашиг нь империализмтай хутгалдаж байв. Жишээ нь чихрийн нишэнгийн худалдаачид.

Мао: Саахар үйлдвэрлэгчид үү?

Гевара: Тийм. Тэд байсан. Харин одоо саахарын бизнесийг улсын болгосон.

Мао: Та нар бүх капиталаа үндсэнд нь АНУ руу хүчээр хураалгачихдаг байсан уу?

Гевара: Бүгдийг нь биш. Магадгүй зарим капиталаа хураалгалгүй зугтаалгаж байсан байх.

Мао: Хүчээр хураалгачихдаг байсан бол нөхвөр авахаар төлөвлөж байна уу?

Гевара: Хэрэв чихрийн компани гурваас илүү сая тонн саахар авсан бол бид 5-25 хувийн хэмжээтэй нөхвөр авна. Гэхдээ худалдсан үнээсээ шалтгаална. Хүмүүс Кубын байдлыг сайн мэдэхгүй учраас энэ талаархи өвөрмөц бодлогыг ойлгохгүй байх.

Мао: Хэвлэлийн мэдээгээр бол Та нар чинь 47 кабаллер (13.71 га газар) газрын хөрөнгө, ашгийг нь жилийн нэг хувийн нэмэгдэлтэйгээр буцаагаад олгочихсон юм биш үү?

Гевара: Гурваас илүү сая тонн саахар хурааж авсан компани л нөхвөр авна. Нөхвөргүйгээр худалдан авалт хийгдэхгүй. Харьцангуй томд тооцогдох канадын хоёр банк байлаа. Тэд манай дотоод, гадаад бодлогыг ойлгон зөвшөөрсөн тул бид улсын болгоогүй.

Мао: Стратегийн хувьд зарим империалист компанийг түр байлгаж, тэвчиж байх нь болох л зүйл. Манай энэ Хятадад ч империалист хэд хэдэн компани байж л байна.

Жоу Эньлай: Жишээ нь HSBC бэлгэ тэмдгийн шинжтэй байж л байна. Энэ бол Хонконг ба Шанхайн банкны корпораци байгаа юм.

Гевара: Тэгвэл тэр HSBC шиг л канадын банкууд Кубад байгаа хэрэг.

Мао: Та нар ажилчин, тариачныг нэгтгэх хэрэгтэй. Тэд олонхи шүү дээ.

Гевара: Хөрөнгөтөн ангийн зарим нөхөд бидний эсрэг эргэж, дайсны лагерьт нэгдээд байна.

Мао: Хэн бидний эсрэг байна, тэд бол манай дайсан шүү дээ. Бид хувьсгалын эсэргүүг даран сөнөөхийн тулд их ч ажил өрнүүлсэн дээ.

Гевара: Хувьсгалын эсэргүүчүүд түрэмгий авир гаргасаар байна. Тухайлбал тэд заримдаа манай зарим арлуудыг эзлэн авдаг. Тэгснийх нь дараа бид тэднийг устгадаг.

Тэднээс бид айхгүй. Тэдний лидерийг нь устгачихна, тэднийг баривчиллаа л бол буудчихна. Тэдний зэвсэг хэрэгслийг шүхрээр хаядаг, бүгд л АНУ-аас ирсэн байдаг.

Мао: Та нар чинь хэд хэдэн америкчуудыг олзоллоо гэв үү?

Гевара: Тэд баривчлагдсан, бид буудчихсан.

Жоу Эньлай: Америкийн Засгийн газар эсэргүүцлээ илэрхийлсэн, харин бид тэдэнд хариуг нь өгсөн.

Мао: Та их хатуу хүн юм. Эцсээ хүртэл хатуу чигээрээ байгаарай. Энэ итгэл чинь, тэгээд энэ империализм гэдэг чинь их хүнд шүү. Хэрэв

тээнэгэлзээд буулт хийгээ л бол империализмд илүү хялбар болно. Та нартай ёстой ажиллаж өгнө дөө.

Гевара: Хувьсгалын эхний шатанд Фидель маань нийтийн орон сууцны фондын асуудлыг шийдвэрлэе гэсэн. Учир нь бүх нийтээрээ өөрийн орон сууцтай болоход нь Засгийн газар хариуцлага үүрч таарна. Тэгээд бид орон сууц эзэмшигч томхон эздийн хөрөнгийг хурааж түүнийг ард түмэндээ тарааж өгсөн. Харин жижиг аж ахуйтай эзэд өмчтэйгээ үлдсэн.

Мао: Дараа нь яасан бэ?

Гевара: Одоо бид хувьсгалынхаа хоёрдахь шатанд шилжиж байна. Нэг хүн бусдыгаа дарлаж ирсэн гаж үзэгдлийг эцэслүүлж байна. Дотоод, гадаад байдалтайгаа уялдуулаад бид манай байлдан олсон эрх чөлөөгөө бэхжүүлж байна. Бичиг үсэг үл мэдэх явдал, ажилгүйдлийг арилгахын төлөө ажиллалаа. Энэ маань тун хүнд нөхцөлд явагдлаа. Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж байна. Газрын реформ цаашдаа хийх болно.

Мао: Онцсайн байна. Та нар Латин Америкт, тэр ч байтугай Ази, Африкт нөлөөлөх болно. Хэрэв Та нар сайн л ажиллах юм бол Латин Америк, Ази, Африк Та бүхний нөлөөн дор байх болно.

Гевара: Ялангуяа Латин Америкт нөлөөтэй байж чадна.

Мао: Латин Америкийн жижиг хөрөнгөтнүүд, үндэсний хөрөнгөтнүүд социализмаас айдаг. Иймд Та бүхэн нийгмийн реформ хийх гэж нэг хэсэгтээ яарахгүй байх хэрэгтэй. Латин Америкийн жижиг хөрөнгөтнүүд, үндэсний хөрөнгөтнүүдийг байлдан авахад чинь ийм алхам хэрэгтэй. Ялалтын дараа бид Чан Кайшийн бизнесийг, Герман, Итали, Японы мэдлийн үйлдвэрүүдийг улсын болгосон. Улсын хөрөнгө 80 хувь болтлоо өссөн. Гэхдээ үлдэх 20 хувийг үндэсний хөрөнгөтнүүддээ үлдээсэн. Тэд нэг сая ажилчин ажиллуулж, харин худалдааны сүлжээг бүхэлд нь хянаж байлаа. Энэ асуудлыг шийдвэрлэхэд бид 7 жилийг зарцуулжээ. Бид үндэсний хөрөнгөтнүүддээ ажлын байр санал болгож, сонгуулийн эрх олгож, хувийн ба улсын холимог үйлдвэр эрхлэх, хувь хүртэх боломж үлдээсэн. Энэ нь ч тэдэнд таалагдаж, гадаадад ч үр ашгаа өгсөн. Энэ бүхнийг азийн хөрөнгөтнүүд хараад баярлаагүй нь мэдээж, гэхдээ

хүлээн зөвшөөрсөн. Тэднийг нэгтгэх боломжийн арга байна, хэрэв зөв ашиглавал худалдан авах бодлого нь явууртай гэдгийг тэд ойлгосон. Хоршооллох маягаар хотын жижиг гар үйлдвэр, жижиг хөрөнгөтнийг ингээд шийдчихлээ.

Гевара: Бид бусад орны туршлага, ялангуяа Хятад болон социалист бусад орны туршлагаас суралцана. Хөрөнгөтнүүдийн тухайд бол хил давуулаад алдчихгүйн тулд бид тэдэнд хүндэтгэлтэй хандана, ажил мөнгө олгоно. Техникчдэд цалин амлана. Жижиг гар үйлдвэрийн уламжлал манайд байхгүй, иймд энэ талаар асуудал гарахгүй. Харин ажилгүй иргэдийг хоршоололд хамруулж, ажлын байр олгоно.

Мао: Куба улс үндэсний хөрөнгөтөнтэй байгаасай гэж АНУ хүсэхгүй. Солонгос ба Зүүн хойд Хятадад, Манжуурт үндэсний хөрөнгөтөн төрөхийг Япон хүсэхгүй л байсан.

Вьетнамд мөн Франц тэгж хандсан. Тэд бол орон нутгийн оршин суугчид нь бүтээгчид байхыг хүсдэггүй юм.

Гевара: Энэ үзэгдэл Латин Америкт бас харагдсан шүү. Хамжлагат ёсыг халахад үндэсний хөрөнгөтнийг империализм ашигласан. Үндэсний хөрөнгөтөн импортод өндөр татвар ногдуулахыг хүсч магадгүй байдалтай байсан. Гэвч тэд үндэсний эрх ашиг дээрээ хатуу зогсож чадаагүй, хэрэг дээрээ тэд империализмтай үгсэн хуйвалдсан.

Мао: Надад асуулт байна. Бразилын металлургийнхан АНУ-тай холбоотой юу? Хэний капитал вэ?

Гевара: Бразилын металлургийн үндсэн үйлдвэрүүд америкийн хөрөнгөөр боссон юм.

Жоу Эньлай: Америкийн капитал хэдэн хувийг эзэлдэг юм бэ? Бразил нь жил бүр 1.6 сая тонн ган үйлдвэрлэдэг шүү дээ.

Гевара: Бразилын томхон үйлдвэр заводын нийт капитал гэж тун ойлгомжгүй юм байна.

Харин тэд технологийн хувьд АНУ-аас бүрэн хараат. Бразил бол том орон. Гэвч яг бодитойгоор бол Латин Америкийн бусад улсаасаа ялгарах юм бараг байхгүй.

Мао: Надад өөр нэг асуулт байна. Кубын эрэгт анхлан газардаад эцсийн ялалтаа хангах хүртлээ Та нар хоёр гаран жилийг зарцуулжээ. Та

нар тариачдыг нягтруулаад ялалтад хүрчээ. Харин Латин Америкийн бусад улс орнууд Танай энэ загвараар замнах магадлал хэр байна вэ?

Гевара: Энэ асуудал яг адилханаар шийдэгдэнэ гэж байхгүй. Хэрэг дээрээ Та нар бол биднийг бодохул илүү их туршлагатай, илүү гүнзгий дүгнэж чадна. Миний үзэж байгаагаар бол, Куба нь Латин Америкийн бусад улс орнуудыг бодвол хувьсгал хийхийн тулд илүү хүнд давхаргатай тулгарсан. Харин ганц таатай хүчин зүйл байсан. Бид империалистуудын цалгар наазгай байдлыг овжин ашиглаж ялалт хангасан. Империалистууд бидэнтэй ажиллахдаа хүчээ төвлөрүүлж чадаагүй. Ялалтаа хангачихаад Фидель өөрсдөөс нь зээл гуйж хамтран ажиллана гэж тэд бодсон. Латин Америкийн бусад улс орнуудад хувьсгал хийх гэсэн нь элдэв эрсдэлтэй тулгарч байна. Жишээ нь Гватемалд хувьсгал хийх гэтэл АНУ тэнгисийн явган цэргээ илгээгээд дотоод хэрэгт нь оролцлоо.

Мао: Дотоод байдлын талаас нь авч үзвэл Латин Америкийн эдгээр улсуудын өвөр хооронд ялгаа гэж байна уу?

Гевара: Улс төрийн хувьд ялгаа байна. Нийгмийн хувьд эдгээр улс орныг хоёр гурван категорт авч үзүүштэй. Гурван улс нь байнгын зэвсэгт тэмцэл хийж байна. Энэ бол Парагвай, Никарагуа, мөн Гватемал.

Мао: АНУ одоо жадаа Гватемал, Никарагуа руу онилоод эхэллээ.

Гевара: Колумб, Перу хоёрт ард түмний томхон хувьсгалт хөдөлгөөн дэгдэх төлөвтэй.

Мао: Миний хэлснээр Колумбиас гадна Перуд хүмүүст газар хэрэгтэй байгаа бус уу?

Гевара: Перугийн ажил явдал ихээхэн сонирхолтой. Тэнд примитив коммунизмын дадал зуршил ямагт байж ирсэн. Испани тэднийг захирч байхдаа феодализм, боолчлолыг авчирсан. Гэвч коммунизмын анхан шатны эгэл хэлбэрийг эндээс арилгаж чадаагүй. Харин бүр эсрэгээр тэр нь одоо хүртэл тэсч тогтоод ирсэн юм билээ. Коммунист нам нь Куско мужид сонгуульд ялсан. Коммунистууд сонгуульд ялахын тулд өрнүүлсэн энэ тэмцэл нь арьсны үзлийн эсрэг тэмцэлтэй давхцан өрнөсөн. Перуд уугуул индианчууд олноороо амьдардаг. Гэвч цагаан арьстан ба метисүүд нь индианчуудыг бодоход газар эзэмших эрх

эдэлж, газрын эзэд болцгоосон байна.

Мао: Нутгийн уугуул оршин суугчид нь хүн ам дотроо 9-10 сая юм. Цагтаа испани хүн ам нь ердөө 10 мянгахан байсан юм билээ.

Гевара: Энэ тоо бол хэтрүүлсэн тоо байж магад. Перу бол 12 сая хүнтэйгээс 10 сая нь нутгийн уугуул иргэд, цагаан арьстан нь 2 сая.

Мао: Перу бол Өмнөд Африктай төстэй юм. Өмнөд Африкт ердөө 3 сая британчууд байгаа шүү дээ.

Жоу Эньлай: Тэнд 3 сая британчууд, нэг сая холландчууд, нэг сая холимог эрлийзүүд, 8 сая хар арьсан, хагас сая энэтхэгчүүд бий. Сүүлчийн хоёр категорийн хүмүүс нь хамгийн ядуу, дорой аж төрж байна. Зөвхөн цагаан арьстан л сонгуулийн эрхтэй.

Гевара: Боолт ёс одоо ч Перуд оршиж байна. Газрыг зардаг шиг хүнийг зарж болдог хуультай.

Жоу Эньлай: Төвдөд хуучин яг тэгдэг л байсан даа.

Гевара: Хоцрогдсон нутгуудад нь оршин суугчид одоо ч мөнгө хэрэглэж сураагүй. Худалдах арилжих болохтой зэрэг бараа өгнө, эсвэл зэс зоос жигнэж өгнө. Цаасан дэвсгэрт тэнд хэрэглэдэггүй.

Мао: Колумб улсад нөхцөл байдал арай ялгаатай байх, тийм үү?

Гевара: Колумб бол феодализм сулхан хөгжсөн газар. Гэхдээ католик шашны нөлөө маш их. Газрын эзэд ба католик сүм хийд нь АНУ-тай үгсэн хуйвалддаг. Орон нутгийн индианчууд нь нэн ядуу, гэхдээ боол биш. Колумбэд зэвсэгт босогчид бий, гэвч тэд тэмцлээ зогсоож байна.

Мао: Куба улс Латин Америкийн бусад улсуудтайгаа дипломат харилцаатай юу?

Гевара: Хэд хэдэн улс нь өвөр хоорондоо үгсэж байгаад Кубатай харилцаагаа тасалсан. Эд бол Гаити, Доминикан, Гватемал юм. Колумб, Сальвадор, Гондурас гурав кубын Элчин сайдад нэгэн зэрэг персон нон-грата өгсөн. Бразил нь Элчин сайдаа эгүүлэн татсан. Гэхдээ өөр шалтгаан ч байсан.

Жоу Эньлай: Нийтдээ 7 улс орон юм шив дээ.

Мао: Тэглээ гээд Куба нь ихэнхи улстай нь харилцаатай байна.

Латин Америкийн 19 улсаас 7-г хас, 12 үлдлээ.

Гевара: Эхэнд миний дурдсан гурван улс–Гаити, Бүгд Найрамдах Доминикан Улс, Гватемалтай Куба ямар ч харилцаагүй, сүүлчийн дөрөв буюу Колумб, Сальвадор, Гондурас, Бразилд Элчин сайдгүй, Түр хамаарагчтай.

Мао: Гватемал, Никарагуа дахь дайны явц ямар байна вэ? Энэ чинь ардын дайн яг мөн үү дээ?

Гевара: Би яг таг хариулж чадахгүй. Гватемал дахь дайн нь ард түмний дайн юм уу гэсэн сэтгэгдэл надад төрдөг. Никарагуад ердийн дайны нэг төрөл л өрнөж байна гэж би үздэг. Тэд Кубаас хол байна. Ямар дайн өрнүүлээд байгаа талаар надад ойлголт алга. Миний энд хэлсэн үгс бол субъектив хариулт гэж үзээрэй.

Мао: Жакоб Арбенс Гусмантай холбоотой ямар хэрэг Гватемалд гарсан юм бэ?

Гевара: Энэ асуудлаар Арбенсын тунхаг гэдгийг би олж үзсэн. Хятад руу гарахасаа өмнөхөн. Тэндхийн хувьсгал ардын шинжтэй байж магад.

Мао: Арбенс одоо Кубад байна уу?

Гевара: Тийм, Кубад байгаа.

Мао: Тэр нөхөр Хятад, Зөвлөлт Холбоот Улсад очсон. Сайн хүн дээ.

Гевара: Бид түүнд итгэж байгаа. Тэрээр өмнө нь алдаа гаргасан, түүнээсээ суралцсан, зассан, одоо түүнд итгэж болно гэж найдаж байна. (Мао дарга зочдыг оройн зоогонд урив. Зоогийн үед дараахи яриа өрнөжээ)

Гевара: Хятад ба Кубын хооронд хоёр зүйл байна. Бараг адилхан юм. Энэ нь намайг маш их догдлууллаа. Та нар хувьсгал хийж байх үед Чан Кайши атаклаж, тэгсэн хэрнээ бүслэгдлээ, дарагдлаа гэдэг байсан. Манай харгис хүчнийхэн ч ийм үг хэлдэг байлаа. Үүнээс гадна тэдний хэрэглэсэн стратеги нь адилхан юм.

Мао: Чан Кайши биднийг нян бактер гэж үзээд устгахыг зорьсон. Бид тэдэнтэй тулалдсан, энэ дайн маань 22 жил үргэлжилсэн. Хоёр удаа хамтран ажилласан, хоёр удаа харилцаа тасарсан, их ч хугацаа

шаардсан. Эхний хамтын ажиллагааны үед бид баруун оппортунизмын алдаа гаргасан. Нам дотор барууны үзэлтнүүд гарч ирсэн. Үр дүнд нь Чан Кайши намд цэвэрлэгээ хийсэн, умард аяны үед дайтах замаар коммунизмыг эсэргүүцэн тэмцсэн. Хоёр дахь шатанд 1924-1927 онд дайнаас өөр юу ч тохиогоогүй. Хүмүүсийг алахаас өөр ямар ч сонголтыг Батист Та нарт үлдээгээгүйн адилаар бидэнд ч ямар ч сонголт үлдээгүй. Кубын ард түмнийг Батист хэрхэн сургасан шиг Чан Кайши бидэнд багшилсан, хятадын ард түмэн ч багшилсан. Гартаа зэвсэг барьж, байлдаан өрнүүлэхээс өөр гарц бидэнд байгаагүй.

Бид хэрхэн тэмцэхээ ч мэддэггүй байжээ. Тийм учраас бид тэмцэлд бэлтгэгдээгүй байсан. Ерөнхий сайд, мөн би болбаас сэхээтэн байсан, Ерөнхий сайдын орлогч Ли Сяньнянь бол ажилчин хүн байсан. Өөр сонголт үнэхээр бидэнд байгаагүй. Чан Кайши алж устгахыг л зорьсон. (Мао дарга хундага өргөв. Кубын хувьсгалын амжилтын төлөө, кубын төлөөлөгчдийн эрүүл энхийн төлөө ерөөлийн үгсийг дэвшүүлэв)

Мао: Дайн эхэлмэгц тэр дайн хэдэн арван жил үргэлжилсэн дээ. Бид баазаа байгуулсан, гэвч баруун оппортунизм руу хальтарч алдсан. Дараа нь хэт зүүний бодлого руу хальтарч, үндсэн баазаа алдсан, их аяны марш хийхээс аргагүй болсон. Эдгээр алдаа бидэнд их зүйлийг сургажээ. Нэг нь баруунтны, нөгөө нь зүүнтний. Япон Хятадад халдаж орж ирэхэд бид дахиад л Чан Кайшитай хамтран ажилласан. Харин Танайд ийм явдал тохиогоогүй дээ.

Гевара. Азаар бидэнд тийм явдал тохиогоогүй.

Мао: Та нар Батисттай хамтран ажиллаагүй л дээ.

Гевара: Батист чинь америкчуудтай мөргөлдөж сөргөлдөөгүй юм чинь.

Мао: Чан Кайши бол Британи, АНУ хоёрын гөлөг шүү дээ. Япон Хятад руу халдан түрэмгийлэхэд Чан Кайши харин ингэхийг нь сайшаагаагүй. Гурав дахь шатанд бид 1937-1945 онд 8 жил Чан Кайшитай хамтран ажиллаж, Японы эсрэг тэмцсэн. Хамтын ажиллагаа сайн байгаагүй. Чан Кайши нь буун өгөгч капиталист ангийн төлөөлөгч, Их Британи, АНУ-ын өмнө бөхөлзөгч байсан. Япон бутцохиулсны дараа эхэлсэн 4 дэх шатанд Чан Кайши бидэн рүү халдсан. Бид нэг жил

хориглон хамгаалаад дараа нь хариу цохилт өгч, гурван жил хагасын дотор 1949 он гэхэд нэгдсэн амжилтдаа хүрч, Чан Кайши Тайвань руу зугтсан. Харин Танайд бол Тайвань арал гэж алга.

Жоу Эньлай: Танайд бол Бинуо гэж арал байна. Тэр арлыг эзэлж аваад тийшээ зугтаагаад гарчих цаг Батистад байсан байх.

Мао: Та нар тэр арлыг эзэлж авсан чинь маш чухал.

Гевара: АНУ манайх руу довтлох боломжоо алдахгүй хадгалсаар байна.

Жоу Эньлай: Американчууд Пиньос арал руу халдахаар завдсан.

Мао: Америкийн империализм бол манай нийтийн дайсан, дэлхийн улс түмний нийтлэг дайсан. Та нар ингэхэд бүгд л цэл залуухан харагдаж байна.

Гевара: Таныг хувьсгалт хэргээ эхлүүлж байхад бид ингэхэд бүр мэндлээ ч үгүй байсан шүү дээ. Зөвхөн энэ хошууч Сунол л төрчихсөн байсан. Тэрээр 35 настай, бидэн дотроо ахмад нь байгаа юм.

Мао: Өнгөрсөн үед бид дайны цаг үед тэмцэж явжээ. Одоо бид бүтээн байгуулалтын төлөө тэмцэж явна.

Сунол: Хувьсгалаа хамгаалахын төлөө.

Гевара: Хятад нь Кубатай өөр нэг хэргийг хуваалцаж байгаа. 1945 онд Хятадын Коммунист Намын их хурал дээр цууриатсан нөхцөл байдлын үнэлгээ байна. Хотын зарим оршин суугчид тосгоныг үл ойшоосон гэх. Манай тэмцлийг хоёр хэсэгт авч үздэг: ууархаг районд партизаны дайн явуулна, хотуудад ажил хаялт зохион байгуулна. Гэвч хотод ажил хаялт зохион байгуулсан нөхөд ууархаг район дахь партизаны дайчдыг хэрэгсэж үзээгүй. Эцсийн бүлэгт ажил хаясан нь ялагдаад дууссан.

Жоу Эньлай: Яг тийм, тэгсэн л хэрэг.

Мао: Хүчээ үрэн таран хийж, сарниулж байж тухлана гэдэг авантюризм шүү. Хотынхон тосгон руу анхаарах сөхөөгүй байх аваас хотын оршин суугчид тариачидтай холбоотон болоход тун амаргүй.

Жоу Эньлай: “Верде Оливио” (“Verde Olivio”) сэтгүүлийн 10 дугаар сарын 5-ны дугаарт Таны бичсэн өгүүллийг уншсан. Кубын хувьсгалын үзэл суртлын талаар өгүүлсэн байна билээ. Таны

өгүүллийн рефератыг уншсан. Таны дэвшүүлсэн асуудлыг уншсан. Та бол оюунлаг сэхээтэн хүн байна гэдэг нь харагдсан.

Гевара: Би бол оюунлаг сэхээтэн шатандаа хүрээгүй явна.

Мао: Та бол зохиогч нь. Энэ өгүүллийн талаархи рефератыг би ч бас уншсан. Таны бодож байгааг тань би бүрэн зөвшөөрч байна. Энэ өгүүлэл Латин Америкт нөлөөлж чадна.

Жоу Эньлай: Та өгүүллийнхээ бүрэн текстийг авч яваа юу?

Гевара: Би эрээдхъе.

Мао: Та өгүүлэлдээ гурван зарчмыг гаргаж тавьжээ. Хүн ард харгис хүчнийг ялж болно. Хүн ард хувьсгал хийх бүх нөхцөл хангагдсан байхыг хүлээх хэрэггүй. Гурав дахь зарчим нь юусан билээ дээ?

Гевара: Гурав дахь зарчим бол Латин Америкт үндсэн зорилт нь хөдөө орон нутаг байх ёстой гэсэн байгаа.

Жоу Эньлай: Хөдөө орон нутгийг хувьсгалд татан оруулахад энэ их чухал шүү.

Гевара: Бид үүнийг маш чухал хэмээн үздэг.

Жоу Эньлай: Латин Америкийн зарим нөхөд тариачдыг сонсохгүй байна. Харин Та нар энэ боломжийг сайн ашигласан учраас амжилтад хүрчээ. Хятадын хувьсгал мөн тийм. Олон нөхөд тариачдын хувь нэмрийг чухал ач холбогдолтой гэж үзээгүй. Харин нөхөр Мао Зэдун энэ үзлийг маш чухалд тооцдог.

Мао: Хотуудад бид оршин тогтнохгүй гэдгийг дайсан бидэнд ягштал ойлгуулчихсан юм.

Тэр Чан Кайши хүмүүсийг алахыг хүсдэг. Тэгэхлээр юу хийх ёстой болж байна?

Гевара: Фидель Кастрод очсон Мао даргын бүтээл дотор маш чухал гэмээр заалтууд байсан. Би эхэнд нь тэмдэглэн хэлэх ёстой байжээ. “Цэргийн олзлогсдыг эмнэ, шархыг нь эдгээ, тэгээд буцаагаад илгээ” гэж. Энэ бол манай тэмцэлд их тустай хэрэг болно гэж бид үздэг шүү.

Мао: Ийм зам бол дайсны цэргийг дотроос нь сарниулдаг юм.

Жоу Эньлай: Таны өгүүлэл ч энэ асуудлыг хөндсөн байсан.

Гевара: Энэ заалт их хожуу нэмэгдэж орсон юм. Эхлээд бид олзлогсод, хоригдлуудын хувцас гутлыг хурааж авдаг байлаа. Учир нь манай цэрэгт тэр нь байхгүй байсан хэрэг. Тэгснээр хэсэг хугацаа өнгөрсний дараа Фидель ингэхийг хориглосон л доо. (Мао Фиделийн эрүүл мэндийн төлөө хундага өргөв)

Гевара: Хүмүүс партизаны дайн хийж байхдаа олигтой хооллож чаддаггүй. Бидэнд оюун санааны хүнс тэжээл ч дутмаг байлаа. Бид материалуудыг уншиж чаддаггүй байв.

Жоу Эньлай: Мао дарга партизаны дайн хийж байх үедээ сонин авчруулахаар хүмүүсийг мөн ч их явуулдагсан.

Мао: Сонин хэвлэлийг мэдээлэл гэдэг талаас нь сайн эмчтэй зүйрлүүлж болно. Дайсны сонин гэхэд л тэдний хөдлөх гишгэхийг байнга мэдээлж байдаг шүү дээ. Энэ чинь мэдээллийн нэг чухал эх сурвалж юм. Бид хувьсгалаа анх хэдэн мянган хүнтэй эхлүүлсэн. Дараа нь арав гаран мянга болсон, дараа нь 300 мянга болж тоо нь өссөн, энэ үедээ бид зүүнтний алдаа гаргасан. Их аяны дараа 300 мянга нь 25 мянга болтлоо хорогдсон. Дайсан биднээс тэгтлээ айхаа больсон. Япончууд Хятадад халдан довтолсны дараа бид Чан Кайшитай хамтран ажиллахыг зорьсон. Тэрээр бидэнтэй хамтран ажиллаж болох юм, учир нь тэд цөөхүүлээ, айх юм алга гэж хэлж байсан.

Япончуудаар биднийг устгуулах нь Чан Кайшийн зорилго байсан. Биднийг Японтой байлдаад эхэлмэгц тэгчихнэ гэж харин тэр бодоогүй байх. Хорин таван мянга байснаасаа нэг сая боллоо, хэдэн зуун мянгаар өслөө. Япон бууж өгсөний дараа Чан Кайши 4 сая цэрэгтэй үлдсэн, тэр хүчээрээ бидэн рүү довтлоход бид нэг сая цэрэгтэй, 100 сая хүн ам бүхий бааз бүс нутагтай байлаа. Ингээд гурван жил хагасын дараа гэхэд бид Чан Кайшийг ялсан. Энэ дайн бол партизаны дайн байгаагүй юм. Таны өгүүлэлд дурдагдсан нисэх онгоц, их буу, танк, энэ бүгд чинь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж чадахгүй байсан юм. Чан Кайшид ч энэ бүхэн байсан шүү дээ. Харин тийм үед нь бидэнд тэдгээрээс нь юу ч байгаагүй. Бид хожим нь хэдхэн их буу л олзлон авсан байх.

Жоу Эньлай: Төгсгөл үед нь бид танк булааж авсан.

Мао: Хамгийн гол нь бид их буунуудыг олзлон авсан явдал. Бид

артиллерын дивиз, артиллерын бригад, артиллерын хороод олныг байгуулж чадсан. Бүх их бууг АНУ-д үйлдвэрлэсэн байсан даа.

Жоу Эньлай: Бээжинг чөлөөлсний дараа бид парад хийсэн дээ. Тэнд дан америкийн зэвсэг техник жагсаж байлаа. Америкчууд яваагүй байсан үе, АНУ-ын Ерөнхий консулын газрынхан, цэргийн атташе нь баярын жагсаалд ирж үзэж сонирхсон доо.

Гевара: Бид байлдаж байх үедээ нэг удаа танк олзлоод бөөн баяр хөөр болж билээ.

Гэтэл Фидель түүнийг хэрэглэхгүй зайлуулна гэсэн. Би тэгэхэд нь сэтгэл дундуур байж билээ.

Мао: Өдөр болгон л агаарт онгоц нисээд байсан байхад хохирол учруулаагүй юу? Хүмүүс өнгөлөн далдлалт хийчихдэг байх л даа. Нов ногоон хувцас өмсчихдөг. Тэгээд өнгөлөн далдалчихна, тийм үү. Та нар бүгд цэргийн форм өмссөн үү? Та нар бүгд цэрэг байсан уу?

Гевара: Гадаад хэргийн дэд сайд энэ Родригес л байгаагүй. Энэ нөхөр гянданд тарчилж байсан юм.

Мао: Та чинь их залуухан харагдаж байна.

Родригес: Би 25 настай.

Мао: Мора, Сунолу Та хоёр бас цэргийнх тийм үү?

Гевара : Морагийн эцэг нь дайны үед буудуулсан юм. Сунол биеийнхээ 6 тус газраа гурван удаа шархадсан. Би өөрөө хоёр удаа шархадсан. Родригесыг гянданд эрүүдэж байлаа. Эхэндээ бидэнд их цөөхөн хүн байсан л даа. Фидель гэхэд л өөрөө гар буугаа гаргаад л байлдана. Бид уртаашаа 12-уулахнаа байлаа.

Мао: Тэнд 18 хүн байгаагүй гэж үү?

Гевара: Тоо нь аажмаар цөөрсөн. Эцсийн бүлэгт бид 12-уулаа л үлдсэн.

Мао: Энэ 12 хүн бол үр хөврөл гэсэн үг. Танайд чинь агаарын хэм их таатай, тийм үү.

Гевара: Кубад хойд нутагтаа 22 градус.

Мао: Танай газар нь ч их сайхан.

Гевара: Газар үр суулгахад тохиромжтой. Элстэй газар нь дал мод

суулгаж болно. Харин ууланд үр тариа ургуулж болохгүй.

Мао: Танай хүн ам дор хаяхад 30 сая хүртэл өсч болох юм байна.

Гевара: Индонезийн Ява арал дээр 50 сая хүн аж төрж байна.

Мао: Та нар тэр генерал Рубен Фульхенсио Батист болон Сальдивар нартаа талархаж яв, бид Чан Кайшид талархдаг шиг л. Чан Кайши хүмүүсийг алснаараа бидэнд том сургамж үлдээсэн.

Альберто Мора Бесерра: Бид Батистдаа талархана. Яагаад гэвэл тэр маш олон хүнийг манай тал руу түлхсэн юм.

Мао: Бидэнд бас империализм гэж бүр сайн багш байна. Империализм бол удаан хугацааны турш бидний сурган хүмүүжүүлэгч байх болно. Бүр хамгийн сайн багш бол америкийн империализм шүү дээ. Та нарт ч бас хоёр багш байна. Батист ба америкийн империализм гэж. Миний ойлгосноор Батист одоо АНУ-д байгаа. Тэр нөхөр эргэж сэргэж дэвжих тухай бодож байгаа даа?

Гевара: Батистыг залгамжлагчид нь одоо 5 фракц болж хуваагдсан. Ерөнхийлөгчид 5 нэр дэвшигч дэвшүүлчихсэн байна. Нэр дэвшигчид нь өвөр хоорондоо ялгарна. Нэг хэсэг нь Батистынхаа эсрэг тэмцэнэ, нөгөө хэсэг нь өөрсдийгөө их бага хэмжээгээр Батист шиг гэнэ.

Мао: Тэгэхлээр тэд бүгдээрээ Батистад тохирохгүй юм шив дээ. Батист одоо хэдтэй билээ?

Гевара: 60 настай.

Мао: Манай Чан Кайши эдүгээ 74-тэй, тэр Бээжинд эргэж ирэхийг өдөр бүр тэчьядан суугаа.

Мора: Энэ 5 нэр дэвшигч бол бүгд намын лидерүүд. Хүмүүс тэдний нэрийг андахгүй, тэд ч бас Кубад эргэж ирэхийг өдөр бүр л тэчьядан суудаг байх.

Гевара: Манай хувьсгал ялсны дараахан 4-5 өдрийн дараа гэхэд л тэд Төв Америкаас Кубад газардахаар төлөвлөсөн байсан. Тэд эргэж ирээд Батистыг түлхэн унагана гэдэг байсан, харин бид өрсөөд хувьсгалаа хийчихгүй юү.

Мао: Төв Америкийн олон орон байна. Миний үзэж байгаагаар Бүгд Найрамдах Доминикан Улс ирээдүйтэй. Тэнд хүмүүс Рафаэл Леонидас Трухильогийн эсрэг жагссаар байна.

“ХУВЬСГАЛ БА ИМПЕРИАЛИЗМ”

Гевара: Хэлэхэд хэцүү. Трухильо бол Латин Америктаа үлэмж төлөвшсөн дарангуйлагч байгаа юм. Америкчууд түүнээс яаж салая даа гэж боддог байх.

Мао: Америкчууд Трухильод дургүй гэж үү?

Гевара: Бүгд л түүнд дургүй, тийм учраас тэр солигдох ёстой.

Жоу Эньлай: Өмнөд Вьетнамын лидер Нго Динь Зьем, Өмнөд Солонгосын лидер Ли Сын Ман нар шиг л.

Мао: Тэр Нго Динь Зьем бол одоо бүхнээс илүү шаналж зовж байна.

Жоу Эньлай: Хөлсний этгээдэд амьдарна гэдэг эгэлгүй дээ.

Мао: Америкчуудад Чан Кайши одоо таалагдахаа больж байна. Бид ч бас түүнд дургүй. Америкийн талд 100 хувь орлоо гээд Чан бүр дордоно. Одоо тэр 99 хувьтай байгаа. Одоо тэр урьдын адил эрх мэдлээ хадгалахыг хүсч байна.

Жоу Эньлай: Энэ бол диалектикийн үзэгдэл юм даа.

Команданте Эдди Сунол: Чан Кайшийг эргэж ирнэ гэж Та нар хүлээж байдаг юм шиг байна.

Мао: Хэрэв тэр АНУ-аас өөрийгөө салгачихвал бид түүнд Засгийн газартаа нэг суудал өгчихнө л дөө.

Жоу Эньлай: Тэгэхдээ тэр эргэж ирэхдээ Тайваниа хамт аваад ирвэл бүр сайн.

Мао: Тэр эргэж ирэх сонирхолгүй байх аа даа.